



**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 01/05

Улаанбаатар хот

2018 оны эд хөрөнгийн тооллогын
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйл, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.2.1, 11.3 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бэлчээрийн менежмент төслийн нэгж-ОНӨТҮГ-ын үндсэн хөрөнгө, эд материалын тооллого явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Г.Пүрэвсүрэн

Төслийн менежер

Гишүүд: А.Гэрэлтуяа

Хүний нөөцийн менежер

Н.Ганболд

Тоног төхөөрөмжийн оператор

Нарийн бичиг: Б.Баярцэцэг

Агрономч

2. Тооллогыг жилд 2 удаа зохион байгуулж, эд хөрөнгийг нүдээр үзэн тоолж, цаашид ашиглах боломжгүй эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж, тооллогын үр дүнг удирдлагад танилцуулж байхыг комиссын ахлагч /Г.Пүрэвсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тооллогын явцад өртгөө элэгдлээрээ нөхсөн буюу эвдэрч хуучран шаардлага хангахгүй болсон хөрөнгийг тоолж, худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах талаар санал гарган зурагжуулж, нийслэлийн өмчийн харилцааны газраар дүгнэлт гаргуулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэн данс бүртгэлээс хасаж, тайлан тооцоонд тусгахыг нягтлан бодогч /Ц.Мөнхдөл/-д үүрэг болгосугай.

4. Даргын 2017 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 07 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.ГАЛДӨЛ

2150300009